ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛГИЙН БИРЖ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/72/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Мүүрь Аудит ХХК-ийн
Захирал У.Оюунаа
Утас: 70150003 Цахим хаяг: info@moore-mongolia.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт 1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 3
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан 4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Зорилтот түвшний гүйцэтгэл 6
3. Аудитын тайлан 7
3.1 Ерөнхий зүйл 7
3.2 Дотоод хяналт 7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 7
3.4 Материаллаг байдал 8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга 8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа 8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин 8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого 9
4.4 Зорилтот түвшний гүйцэтгэл 10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 10
5.1 Шилэн дансны мэдээлэл 10
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 11
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал 11
8. Аудитын илрүүлэлт 11
8.1 Зөвлөмж 11
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/612

танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ЭРДЭС БАЯЛГИЙН
БИРЖ ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ж.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь үйл ажиллагааны зардлыг 964.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 102.7 сая төгрөгөөр нийт 1,067.5 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 327.3 сая төгрөгийн зардал гарган алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн тайланд 1 зорилго, 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч удирдлагын шийдвэр гаргалтын удаашралтай байдлаас төлөвлөсөн ажлууд гүйцэд хэрэгжээгүй бөгөөд биелэлтийг тайлагнаагүй байна.

2021 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ХЭХ/007 дугаартай "Компанийн хувьцааг хуваах тухай", ХЭХ/008 дугаартай "Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай'' тогтоолын дагуу энгийн хувьцааны нэг бүрийн үнийг нэг төгрөгөөр тогтоон дүрмийг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
90191203 96

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,639,168.25	286,790.25
1.1.2	Дансны авлага	1,037,750.00	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	3,420,000.00	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	70,000.00	70,000.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	176,916.67
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**28,166,918.25**	**533,706.92**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	775,812.50	155,162.50
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.3	Клирингийн тооцоо	-	-
1.2.4	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**775,812.50**	**155,162.50**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**28,942,730.75**	**688,869.42**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1	**Өр төлбөр**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	1,758,175.85	13,628,206.05
2.1.1.2	Цалингийн өглөг	723,972.32	18,310,422.32
2.1.1.3	Татварын өр	16,646,096.52	33,808,321.32
2.1.1.4	НДШ-ийн өглөг	34,303,526.70	81,006,270.70
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	35,049,315.07	95,462,341.53
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц/Өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	18,000,000.00	20,699,575.00
2.1.1.11	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**106,481,086.46**	**262,915,136.92**
2.1.2	**Урт хугацаат өр төлбөр**		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /Өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	464,000,000.00	606,667,000.00
2.1.2.5	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**464,000,000.00**	**606,667,000.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**570,481,086.46**	**869,582,136.92**
2.3	**Эздийн өмч**		
2.3.1	Өмч: -төрийн	600,000.00	600,000.00
2.3.2	-хувийн	400,000.00	400,000.00
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(542,538,355.71)	(869,893,267.51)
2.3.10	**Эздийн өмчийн дүн**	**(541,538,355.71)**	**(868,893,267.51)**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**28,942,730.75**	**688,869.41**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	**Борлуулалтын орлого (цэвэр)**		
2	Борлуулалтын өртөг	-	-
3	**Нийт ашиг (алдагдал)**	**-**	**-**
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	350,389.73	-
6	Ерөнхий ба удирдлагын зардал	451,648,686.4	266,941,885.43
7	Санхүүгийн зардал	35,049,315.07	60,413,026.47
8	Бусад зардал	-	-
9	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**(486,347,611.74)**	**(327,354,912)**
10	Орлогын татварын зардал	35,038.97	-
11	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**(486,382,650.71)**	**(327,354,911.80)**
12	**Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)**	-	-
13	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**(486,382,650.71)**	**(327,354,911.80)**
14	**Бусад дэлгэрэнгүй орлого**	**-**	**-**
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	**-**	**-**
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	**-**	**-**
	Бусад олз (гарз)	**-**	**-**
15	**Орлогын нийт дүн**	**(486,382,650.71)**	**(327,354,911.80)**
16	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**	**-**	**-**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2019 оны 12-р сарын 11-ний үлдэгдэл**	1,000,000.00	-	(56,155,705.00)	(55,155,705.00)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
3	**Залруулсан үлдэгдэл**	1,000,000.00	-	(56,155,705.00)	(55,155,705.00)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(486,382,650.71)	(486,382,650.71)
5	**2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	1,000,000.00	-	(542,538,355.71)	(541,538,355.71)
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
7	**Залруулсан үлдэгдэл**	1,000,000.00	-	(542,538,355.71)	(541,538,355.71)
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(327,354,911.80)	(327,354,911.80)
9	**2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	1,000,000.00	-	(869,893,267.51)	(868,893,267.51)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	01-р сарын 01	12-р сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	436,309,171.75	167,957,128.00
	Ажиллагчдад төлсөн	184,565,100.00	134,883,968.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	20,080,338.00	5,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	584,710.00	487,700.00
	Ашиглалтын зардалд төлсөн	18,000,000.00	26,424,600.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	3,015,303.00	-
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	210,063,720.75	1,160,860.00
1.3	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн**	**(436,309,171.75)**	**(167,957,128.00)**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	350,390.00	3,921,750.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	3,921,750.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	350,390.00	-
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,399,050.00	1,984,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,241,300.00	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	4,157,750.00	1,984,000.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн**	**(5,048,660.00)**	**1,937,750.00**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	464,000,000.00	142,667,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	464,000,000.00	142,667,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**464,000,000.00**	**142,667,000.00**
	Валютын ханшийн зөрүүгийн ашиг (алдагдал)	**-**	**-**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**22,642,168.25**	**(23,352,378.00)**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**997,000.00**	**23,639,168.25**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**23,639,168.25**	**286,790.25**

2.5 Зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2.1	Зээлийн хүүгийн зардал	35,049.3	51,040.0	60,413.0	(9,373.0)	118.4
2.2	Цалингийн зардал	117,221.8	553,440.0	206,264.0	347,176.0	37.3
2.3	Нийгмийн даатгалын шимтгэл	24,510.4	69,180.0	27,140.9	42,039.0	39.2
2.4	ТУЗ-ийн зардал	-	-	2,520.0	(2,520.0)	0.0
2.5	Оффисын түрээс	36,000.0	79,200.0	28,500.0	50,700.0	36.0
2.6	Бичиг хэрэг	2,383.4	2,254.5	1,169.0	1,085.5	51.9
2.7	Хангамжийн материал	-	2,670.0	674.4	1,995.6	25.3
2.8	Танилцуулга,зар сурталчилгаа, мэдээлэл	-	15,000.0	-	15,000.0	-
2.9	Дотоод албан томилолт	-	14,896.0	-	14,896.0	-
2.10	Зөвлөх үйлчилгээний төлбөр	269,672.5	133,000.0	-	133,000.0	-
2.11	Сургалтын зардал	300.0	5,745.0	-	5,745.0	-
2.12	Шуудан, харилцаа холбоо	-	7,390.0	-	7,390.0	-
2.13	Нийгмийн арга хэмжээний зардал	-	30,000.0	-	30,000.0	-
2.14	Элэгдлийн зардал	465.5	-	620.7	(620.7)	-
2.15	Даатгалын зардал	-	1,000.0	-	1,000.0	-
2.16	Хүлээн авалт зардал	451.9	-	-	-	-
2.17	Банкны шимтгэл	63.2	-	52.86	(52.86)	
2.18	Засварын зардал	580.0	-	-	-	-
	Дүн	486,698.0	964,815.5	327,354.9	637,460.6	
	Хөрөнгө оруулалтын зардал	-	102,751.5	-	102,751.5	-
	Нийт дүн	**486,698.0**	**1,067.5**	**327,354.9**	**740,212.1**	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хуулийн дагуу тооцоолох, Нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл, тайланг тулган шалгах, зээлийн хүүгийн зардлыг гэрээний дагуу зөв тооцох зэрэг асуудалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Мүүрь аудит ХХК-ийн ахлах аудитор М.Мөнхцэцэг, аудиторын туслах А.Анужин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Н.Гэрэлчимэг, мэргэжлийн үйлчилгээ хариуцсан захирал У.Оюунаа тус тус хэрэгжүүлсэн.

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Мүүрь Аудит ХХК-нд 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 22/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн үйл ажиллагаа төслийн шатандаа явж буй учир одоогоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, нэгжийн орон тоо байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 327.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн зорилго нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд уул уурхайн салбарын түүхий эдийн экспортыг зохицуулалттай, зохион байгуулалттай зах зээлээр дамжуулан нээлттэй, ил тод хэлбэрээр арилжаалах олон улсын жишигт нийцсэн зах зээл бий болгоход оршино.
Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа гэж тодорхойлжээ.
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 60.0 хувийг төр буюу Эрдэнэс Монгол ХХК эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК нь үүсгэн байгуулагчийн 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 01 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8 дах заалт “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.7 дах заалт “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.5-0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын цалинг 1.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн

эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд биржийн үйл ажиллагаа төслийн шатанд явж буй учир арга хэмжээ аваагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”-д заасны дагуу оффисын түрээсийн зардлыг 7.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
Удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ажлын цагийг багасган үндсэн цалинг 2 дахин бууруулан олгосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 болон 2 дах хэсэгт өөрчлөлт орсон-2021 оны 6 дугаар сарын 11
- Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 тоот тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүү байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=(2-1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,639.2	286.8	(23,352.4
Дансны авлага	1,037.8	-	(1,037.8)
Бусад авлага	3,420.0	-	(3,420.0)
Бараа материал	70.0	70.0	-
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	176.9	176.9
Үндсэн хөрөнгө	775.8	155.2	(620.7)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**28,942.7**	**688.9**	**(28,253.9)**
Өр төлбөрийн дүн	570,481.1	869,582.1	299,101.1
Богино хугацаат өр төлбөр	106,481.1	262,915.1	156,434.1
Урт хугацаат өр төлбөрийн дүн	464,000.0	606,667.0	142,667.0
Өмч: -төрийн	600.0	600.0	-
-хувийн	400.0	400.0	-
Хуримтлагдсан ашиг	(542,538.4)	(869,893.3)	(327,354.
Эздийн өмчийн дүн	(541,538.4)	(868,893.3)	(327,3549
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**28,942.7**	**688.9**	**(28,25.9)**

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Богино хугацаат өр төлбөр 156.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд тайлант хугацаанд үүссэн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, ажиллагсдын 10-12 сарын цалин олгоогүй, зээлийн санхүүжилтэд тооцсон хүүгийн өглөг нөлөөлсөн байна.
- Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 142.6 сая төгрөгөөр өссөн нь ‘Зээлийн санхүүжилт олгох тухай” гэрээний дагуу хувьцаа эзэмшигч МСХ Клиринг ХХК-аас үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор авсан зээл байна.

Компанийн үйл ажиллагаа төслийн шатанд явж байгаа болон өөрийн үйл ажиллагааны орлого олоогүй учир үйл ажиллагааны зардлыг зээлээр санхүүжүүлж байгаа бөгөөд өр төлбөрийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан аргачлалын дагуу зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд зардлын талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, санхүүгийн зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 184.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төлөвлөгдсөн ажил хийгдээгүй албан томилолт, зар сурталчилгаа, сургалт, зөвлөх үйлчилгээний зардал зарцуулагдаагүйгээс шалтгаалжээ.

4.4 Зорилтот түвшний гүйцэтгэл

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, компанийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 5.1-т заасны дагуу тухайн байгууллагын жил бүрийн бизнес төлөвлөгөө, их хэмжээний хэлцлийг батлах, гүйцэтгэх удирдлага нь хөлсөөр ажиллах гэрээний 3.4.3-т заасны дагуу “ТУЗ-өөс баталсан компанийн стратегийн зорилт, хөрөнгө оруулалтын бодлого, урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх биелэлтэд хяналт тавих” үүрэгтэй.

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 20/08 дугаар тогтоолоор Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт үйл ажиллагааны зардлыг 964.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 102.7 сая төгрөгөөр нийт 1,067.5 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Тайлан онд 327.3 сая төгрөгийн зардал гарган алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс 740.2 сая төгрөг буюу 69.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх ТУЗ-ийн удирдамж гараагүй, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй тул төлөвлөгдсөн зарим зардлууд гараагүйтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК нь тайлант онд нийт 160.6 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 142.6 сая төгрөгийн орлого, 18.0 сая төгрөгийн зарлагын мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулах зөвлөмж хүргүүлэх.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн компанийн өмнөх оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй учир зөвлөмж өгөгдөөгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад илэрсэн доорх асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

- 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн ХЭХ/010 дугаартай Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн “Компанийн өрийг хувьцаагаар солих” тухай тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 12/007 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлийн ‘’Зээлийн санхүүжилтийн гэрээг дүгнэж, дуусгавар болгох ажлыг хэрэгжүүлэх тухай” тогтоолыг үндэслэн зээлийн санхүүжилтийн гэрээг дүгнэсэн ажлын тайлан 2022 онд бэлтгэгдсэн, ТУЗ-ийн тогтоол, шийдвэр эцэслэж гараагүй;
- Засгийн Газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлсан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах;
- Тус компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө, төсөв ТУЗ-ийн хурлаар батлагдаагүй байгаа тул цаашид байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг ханган ажиллах эсэх;

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой 0.4 сая төгрөгийн алдаа илэрсэнд цаашид анхаарч ажиллах талаар зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 0.4 сая төгрөгийн алдаа нь тогтоосон 3.2 сая төгрөгийн түвшнээс 2.8 сая төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой

1.1 Илрүүлэлт:

Үндсэн ажилтны цалингаас хувь хүний орлогын албан татвар суутгахдаа хөнгөлөлт эдлүүлээгүй татвар суутгасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдын цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос татвар суутгахдаа хөнгөлөлтийг хасаж тооцох, жилийн эцэст хуульд заасан орлогын шатлалын дагуу татварыг тооцоог хийж, суутгасан татварыг хуулийн хугацаанд төлдөг байх.

2. *Өглөгийн данстай холбоотой*

2.1 Илрүүлэлт:

Журналаарх нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн үлдэгдлийг нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад 0.2 сая төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Сар, улирал тайлант хугацааны тасалбар болголтоор нийгмийн даатгалын шимтгэлийн үлдэгдлийг нийгмийн даатгалын баталгаажсан тайлантай тулган шалгаж, үнэн зөв тайлагнадаг байх.

3. Хүүгийн зардалтай холбоотой

3.1 Илрүүлэлт:

Эрдэнэс Монгол ХХК-аас авсан зээлийн санхүүжилтийн дүнд гэрээний дагуу хүүгийн зардлыг давтан тооцоолоход 0.1 сая төгрөгөөр хүүгийн зардал, өглөгийг санхүүгийн тайланд илүү илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ, 14.4.3. бүх өр төлбөр, 14.4.6. бүх зардал" заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Зээлийн хүүгийн зардал, өглөгийг гэрээний дагуу үнэн зөв тооцон тайлагнадаг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК	АХГ-2022/72/НА-СТА-ТӨА	Үндсэн ажилтны цалингаас ХХОАТ суутгахдаа хөнгөлөлт эдлүүлээгүй татвар суутгасан. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ заалттай нийцэхгүй байна.	Зөвлөмж өгөв	1	144.0									1	144.0
2	Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК	АХГ-2022/72/НА-СТА-ТӨА	Хувьцаа эзэмшигч Эрдэнэс Монгол ХХК-аас авсан Зээлийн санхүүжилтийн дүнд гэрээний дагуу хүүгийн зардлыг давтан тооцоолоход 109.7 мянган төгрөгөөр хүүгийн зардал, өглөгийг илүү илэрхийлсэн.	Зөвлөмж өгөв	1	109.7										109.7
3	Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК	АХГ-2022/72/НА-СТА-ТӨА	Журналаар НДШ-ийн өглөгийг НДШ-ийн тайлантай тулган шалгахад 157.3 мянган	Зөвлөмж өгөв .	1	157.3									1	157.3

			төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.													
ДҮН					3	411.0									3	411.0
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Монголын Эрдэс Баялгийн Бирж ХХК	АХГ-2022/72/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 142,667.0 мянган төгрөгийн орлого,18,000.0 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг ил тод байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмж өгөв	1	160,667.0									1	160.667.0
	ДҮН				1	160,667.0									1	160,667.0
НИЙТ ДҮН					4	161,078.0									4	161,078.0

ТЭМДЭГЛЭЛ